ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 05 өдөр Дугаар 107 Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн "Улаанбаатар дулааны сүлжээ" Төрийн өмчит хувьцаат компанийн 2018-2019 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч нийт 830.4 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1."Улаанбаатар дулааны сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн 2018-2019 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2."Улаанбаатар дулааны сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Баярсайханд санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн, дотоод хяналтыг сайжруулж дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

2.1.Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах;

2.2.Байгууллагын үйлдвэрлэл, эдийн засгийн үр ашгийг сайжруулж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактаар олгосон эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулах, зорилтот түвшин үзүүлэлтийг хангах, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхгүй байх;

2.3.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг худалдан авахдаа Төрийн өмчийг бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авч ажиллах;

2.4.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг зөрчин санхүүгийн бүрдэл дутуу баримтаар хийгдсэн ажил гүйлгээний баримтыг нөхөн бүрдүүлэх;

2.5.Тогтоолын хавсралтад дурдсан үргүй зардал болох 14.4 сая төгрөгийг буруутай этгээдээр төлүүлж байгууллагыг хохиролгүй болгох;

2.6.Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах төлөвлөгөөний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэст ирүүлэх;

132001330

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн Хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн 02 дугаар тушаалын хавсралт

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах
арга хэмжээний жагсаалт

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга		Хариуцах эзэн	Дүн /сая.төгрөг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	ХААТөлөвлөгөөнөөс гадуур худалдан авсан бараа материал, сэлбэг, хэрэгслэл		Захирал Г.Баярсайхан Ерөнхий ня-бо Л.Баярсахйан	63.4	Сангийн сайдын 2018 оны 261 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ыг мөрдөж ажиллах
2	ТБОНӨХөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн заалт зөрчсөн		Захирал Г.Баярсайхан Ерөнхий ня-бо Л.Баярсахйан	471.0	ТБОНӨХөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах
3	Хэрэгцээнээс илүү авсан бараа, материал		Захирал Г.Баярсайхан Ерөнхий ня-бо Л.Баярсахйан	30,2	Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг мөрдөж ажиллах
4	Үндсэн баримтгүй	Дутуу бүрдэл	Захирал Г.Баярсайхан Ерөнхий ня-бо Л.Баярсахйан	13,5	Иргэний хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалтыг мөрдөж ажиллах,
		Тушаал шийдвэргүй		4,0	
		Суутган тооцох		47,8	
		Томилолт болон бусад		200,3	
5	Үргүй зардал		Захирал Г.Баярсайхан Ерөнхий ня-бо Л.Баярсахйан		Төсвийн тухай хуулийн "25.10.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно." заалтыг мөрдөж ажиллах
	Дүн			**830,4**	